

Монгол Улс
НЭЗХДШ болон ТС-ийг боловсруулах хүрээнд Дархан-Уул аймгийн хувийн хэвшлийн
байгууллагуудтай хийсэн зөвлөлдөх уулзалт
2017 оны 9-р сарын 7

Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл ibaatarkhuu@worldbank.org и-мэйл хаягаар Б. Индратай холбогдоно уу.

Дэлхийн Банк Групп (ДБГ) нь Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодлыг сонсох, солилцох зорилгоор 2017 оны 9 дугаар сарын 7-нд Дархан-Уул аймгийн хувийн хэвшлийн 14 байгууллагатын төлөөлөлтэй уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

- 1) Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
- 2) Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
- 3) Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Ангилал	Оролцогчдын санал
<p>Улс орны хөгжлийн дүн шинжилгээний талаар санал (ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга зам, боломж, сорилт, бэрхшээл)</p>	<p>Боломж</p> <ul style="list-style-type: none"> • Дарханд аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх их нөөц бололцоо байгаа учир төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг энэ чиглэлд хөгжүүлэх хэрэгтэй. • Дарханд бүх төрлийн үйлдвэрлэл байна. Эко бүтээгдэхүүнүүд болон байгалийн нөөц элбэг дэлбэг учир тэдгээрийг боловсруулбал олон улсад том зах зээл байна. • Бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх тааламжтай орчин нөхцөл байна. • Стандарт, хэм хэмжээг сайжруулж, зах зээлийн стратегийг илүү нарийн болгон боловсруулж, хөрөнгө оруулалт хангалттай олноор нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих боломжтой. <p>Сорилт</p> <ul style="list-style-type: none"> • Импортын бүтээгдэхүүнүүдийн үнэ өртөг бага байгаа нь дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж өгдөггүй. • Төр засаг хувийн бизнест хэтэрхий их оролцогоос болж зах зээлийн зарчим алдагдаж, бизнесүүдийн шударга өрсөлдөөнийг гажуудуулдаг. Засгийн газраас олгож буй санхүүжилт томоохон компаниудад очдог бөгөөд Засгийн газрын зарим төслүүдийг хувийн хэвшил хэрэгжүүлэх боломжгүй байдаг. • Төр-хувийн хэвшлийн харилцан яриа, харилцааг хөгжүүлэхийн тулд хоёр талыг зөвшилцөх, уулзаахыг илүү олшруулах хэрэгтэй.

- Хээл хахууль том асуудал болсон. Жишээ нь газар ашиглах зөвшөөрөл авахал хахууль авдаг. Үйл ажиллагаа эрхлэхэд Засгийн газрын бодлогын дагуу хуучин үйлдвэр байсан газарт газар ашиглах зөвшөөрөл олгодог нь тухайн газар байгаа хуучин үйлдвэрийг сэргээх, газрыг цэвэрлэхэд илүү их санхүүжилт гаргахад хүргэдэг. Засгийн газрын хүнд суртал мөн асуудал болж байна. Авлига, залилан болон баян, ядуугийн ялгаа, орлогын тэгш бус байдал нэмэгдэж байна.
- Орон нутгийн эко бүтээгдэхүүнүүдийг экспортод гаргах нөөц боломж байгаа боловч стандарт, журам их байдаг бөгөөд хувийн хэвшлийн байгууллага эдгээрийг биелүүлэх шаардлагатай болдог. Мөн чанар, үр ашгийг сайжруулахын тулд өндөр өртөг шаардагддаг. Гэсэн хэдий ч Засгийн газраас одоогийн байдлаар ямар ч дэмжлэг байхгүй байгаа ба хувийн хэвшилд олгож байгаа гэж нэрлэгдэж буй Засгийн газрын дэмжлэг харагдахгүй байна.
- ЖДҮ-үүдийг дэмжинэ гэж олон жил ярьж байгаа боловч бодит дэмжлэг байхгүй, ЖДҮ-үүд өөрсдийгөө дэмжин, өндөр хүүтэй зээл авч байна. ЖДҮ-дэд олгох зээлийн хүү харьцангуй доогуур байгаа боловч 5 жилийн хугацаатай л байдаг. Орон нутгийн бараа бүтээгдэхүүнүүд улирлын чанартай байдаг тул зээлийн эргэн төлөгдөх хугацааг уртасгаж, хамгийн багадаа 10 жил болгох хэрэгтэй. Жишээ нь улс оронд худалдан авах чадвар буурч байгаагаас болж зөгийн балны үйлдвэрлэлд өнгөрсөн жилийн үлдэгдэл хуримтлагддаг. Мөн ЖДҮ-дийн зээлд зөвхөн төөн цооны бизнесүүд хамрагдан, зээл маш өрсөлдөөнтэй, хатуу нөхцөлтэй байдаг.
- Тусгаарлагдсан, жижиг хэмжээний үйлдвэрлэл, дэлгүүрүүд орон нутагт элбэг байдаг. Эдгээрийг нэгтгэн, боловсруулах салбарыг хөгжүүлэх боломжтой. Боловсруулалт багатай, нэгдээгүй байвал бүтээгдэхүүнд илүү бага өртөг шингэхэд нөлөөлдөг.
- Дотоодын зах зээл хязгаарлагдмал тул экспортыг хөгжүүлэх нь том боломж боловч хэрхэн хөгжүүлэх гэдэг нь одоогоор асуулт байна. Экспортод бүтээгдэхүүн гаргахад маш их хэм хэмжээ, баримт бичгийг шаарддаг, ялангуяа хүнсний бүтээгдэхүүн дээр. Бүтээгдэхүүний илүүдлийг экспортод гаргах хэрэгтэй. Экспортыг хөгжүүлэхдээ илүү дээд зэрэглэлийн болон нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүндээ төвлөрөх шаардлагатай.
- Зах зээлийн судалгаа явуулахад шаардлагатай мэдээ, мэдээлэл, дата үнэн зөв биш байдаг. Судлаачдыг авч ажиллуулах өндөр өртөгтэй болохоор олон улсын зах зээлд гарахад хүндрэлтэй байна. Мөн бараа бүтээгдэхүүний талаар судалгаа хийж, хөгжүүлэхэд өртөг өндөр байдаг тул бүтээгдэхүүнийг сайжруулахад хэцүү байдаг.
- Хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлт, эрэлт хэрэгцээ хоорондоо нийцдэггүй. Техник, мэргэжлийн боловсролын сургууль, сургалт төгсөгчдийн чадвар хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцдэггүй, тэдгээрийн сургалт нь ажлын байран дээр хэрэгтэй байгаа ур чадварыг эзэмшүүлэх хэрэгтэй. Нийслэл хотоос гадуурх боловсрол муу бөгөөд үүнийг даган залуус нийслэл рүү ирж байна.
- Хэдэн жилийн өмнө уул уурхайн салбар хурдацтай тэлж, олон хүмүүс уул уурхай руу ажиллахаар явах хүртэл хувийн хэвшилд байнга ажиллах мэргэжилтэн тогтвортой ажилладаг байсан. Засгийн газраас аж ахуйн

	<p>нэгжүүдийг хэдэн ажлын байр бий болгосон гэдгийг зөвхөн тооцохоос гадна хувийн компаниудад ажиллаж буй хүмүүсийн хэдэн жил ажилласныг мөн тооцдог байх хэрэгтэй. ажилласан жилийг мөн тооцон хянаж байх хэрэгтэй.</p>
<p>ДБГ-ын стратеги, түншлэлийн талаар өгсөн санал</p>	<p>Салбарууд:</p> <ul style="list-style-type: none"> • Ядуурлыг бууруулахад төвлөрөх хэрэгтэй. Ажлын байрыг бий болгож, ЖДҮ-дийг дэмжсэнээр баялгийг эрх тэгш хуваарилах боломжтой. • Боловсролын салбарын шинэтгэлийг явуулж, чанар, хүртээмжийг сайжруулах тал дээр дэмжлэг үзүүлэх. Цэцэрлэг, сургуулийн тоо хангалтгүй байгаагаас болж жишээ нь одоо цэцэрлэгийн элсэлтийг цахим сугалаагаар удирддаг болсон. • Засгийн газрын зүгээс тэргүүлэх салбар болсон хөдөө аж ахуйн салбарын дэмжлэгийг нэмэгдүүлж, тэр дундаа үйл ажиллагааны үр ашиг, орлогыг нэмэгдүүлэхэд хэрэгтэй тоног төхөөрөмж авахад дэмжлэг үзүүлэх. • Дэд бүтэц одоо хүртэл тэргүүлэх салбар байсаар байна. Хөдөө орон нутагт байгаа зарим айл өрхүүд цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй тулд сэргээгдэх эрчим хүчийг цаашил хөгжүүлэхэд анхаарах. • Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх. Хувийн хэвшлийн байгууллагууд бага хүүтэй, урт хугацаатай санхүүжилтийг эрэлхийлсээр байна. • ЖДҮ-дийг хөгжлүүлэх, ЖДҮ-дэд санхүүжилт олгохдоо хараа хяналт, мониторингийг сайжруулах. Хэрэв санхүүжилт олгох бол хэрэгцээ шаардлаганд хүрэхгүй жижиг хэмжээний санхүүжилт олгосноос хэрэгцээг хангахуйц хэмжээтэйг олгох хэрэгтэй. • Одоо үйл ажиллагаагаа амжилттай явуулж байгаа аж ахуйн нэгж, бизнесүүдийг илүү хүчин чадлаар ажиллахад нь дэмжлэг үзүүлэх нь илүү үр дүнтэй, үр ашигтай байж болзошгүй. Ингэснээр мөн ажлын байрыг нэмэгдүүлж болно. <p>Арга зам, хэрэгжилт:</p> <ul style="list-style-type: none"> • ДБГ Засгийн газартай хамтран ажиллахаас гадна мэргэжлийн, салбарын холбоодтой шууд ажиллах хэрэгтэй. Нөгөө талаас, нэг салбарт ажилладаг талууд хамтраад санхүүжилтийн хүсэлт гаргах хэрэгтэй. • Төслийн санхүүжилт зорилтот хүмүүстээ хүрдэггүй тохиолдлууд байна, тиймээс төслийн хараа хяналтыг үргэлжлүүлэх, илүү бэхжүүлэх хэрэгтэй.
<p>ДБГ-ын оролцооны талаар хэлсэн санал</p>	<ul style="list-style-type: none"> • Экспортыг дэмжих төсөл нь хамрагдах аж ахуйн нэгжүүдэд тодорхой хэмжээний орлоготой байх хэрэгтэй гэж хязгаарлалт тавьсан. Анхны хөрөнгө оруулалтын өртгөө нөхөөгүй, илүү шинэ аж ахуйн нэгжүүдэд зориулан шаардлагаа өөрчлөхийг судлах.
<p>Бусад</p>	<ul style="list-style-type: none"> • Энэ хэлэлцүүлэг уулзалтанд хувийн хэвшил, Засгийн газрын төлөөлөл хамт оролцсон бол илүү үр дүнтэй байх байсан.

Уулзалтын үеэр оролцогчдоос авсан товч судалгааны хариу:

1. Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг бууруулж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

— Хувийн хэвшлийг хөгжүүлэх	11	79%
— Санхүүгийн зах зээл	9	64%
— Боловсрол	8	57%
— Авлигатай тэмцэх	6	43%
— Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	6	43%
— Хөдөөгийн хөгжил	6	43%
— Эрүүл мэнд	6	43%
— Хүнсний аюулгүй байдал	6	43%
— Худалдаа, экспорт	6	43%
— Төрийн удирдлага/шинэтгэл	3	21%
— Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	2	14%
— Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	2	14%
— Эрх тэгш боломжоор хангах	2	14%
— Ус, ариун цэврийн байгууламж	2	14%
— Байгалийн нөөцийн удирдлага	1	7%
— Зам, тээвэр	1	7%
— Эрчим хүч	1	7%
— Эдийн засгийн өсөлт	0	0%
— Гамшгийн эрсдэлийн удирдлага	0	0%
— Гадаадын хөрөнгө оруулалт	0	0%
— Хотын хөгжил	0	0%
— Нийгмийн хамгаалал	0	0%
— Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах	0	0%
— Бусад	0	0%

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж Та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	9	64%
Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих	6	43%
Хүний хөгжлийг дэмжих	6	43%
Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	4	29%
Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	3	21%
Бүгд чухал	1	7%